



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/8/НА-СТА-ТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Мандалговь хот
2022 он

Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70593113
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Товчилсон үгийн жагсаалт.....	2
2. Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Албан шаардлага.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

1.Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮДАХ	Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 № 90.

танай _____-ны № _____-т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА М.БАЯРСҮХ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020918

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		625,431.2	936,933.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	95,686.1	189,022.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	232,726.2	386,290.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	297,018.9	359,620.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	2,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,135,336.9	4,092,335.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,135,336.9	4,092,335.3
39200	Биет хөрөнгө		4,048,525.7	4,005,978.6
39300	Биет бус хөрөнгө	13	86,811.2	86,356.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,760,768.1	5,029,268.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		18,733.3	6,962.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	18,733.3	6,962.8
41300	Өглөг	17а, 17б	18,733.3	6,962.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,742,034.8	5,022,305.5
51	Засгийн газрын хувь оролцоо		4,742,034.8	5,022,305.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,771,754.0	1,771,754.0
51200	Хуримтлагдсан үр дүн		170,067.4	450,338.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,800,213.4	2,800,213.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,760,768.1	5,029,268.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,680,240.7	2,570,400.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		25,802.7	67,688.2
110	Орлогын албан татвар		20,217.1	16,751.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		20,217.1	16,751.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		4,790.7	9,276.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	445,944.5	542,169.5
120	Нийтлэг татварын бус орлого		445,944.5	542,169.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,208,493.4	1,960,543.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,409,617.6	2,270,860.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,409,617.6	2,270,860.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,801,978.9	2,195,146.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,061,285.5	1,082,635.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		136,141.0	139,688.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		120,576.5	127,707.8
2104	Хангамж, бараа материалын зардал		63,562.0	110,703.4
2105	Нормативт зардал		55,843.1	177,708.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,540.9	33,222.4
2107	Томилолт, зочны зардал		9,138.0	6,329.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		41,407.6	22,632.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		301,484.3	494,518.4

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		607,638.8	75,714.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		270,623.0	299,540.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		40,130.7	28,227.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		230,492.3	271,313.0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,511,542.5	0.0	4,511,542.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,511,542.5	0.0	4,511,542.5
9	Тайлант үеийн үр дүн	230,492.3	0.0	230,492.3
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,742,034.8	0.0	4,742,034.8
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,742,034.8	0.0	4,742,034.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,957.7	0.0	8,957.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,750,992.5	0.0	4,750,992.5
19	Тайлант үеийн үр дүн	271,313.0	0.0	271,313.0
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,022,305.5	0.0	5,022,305.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,354,803.6	2,024,378.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	25,802.7	67,688.2
110	Орлогын албан татвар	20,217.1	16,751.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	20,217.1	16,751.5
113	Хөрөнгийн албан татвар	795.0	41,660.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,790.7	9,276.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,117.5	7,315.2
1181	Газрын төлбөр	673.2	1,911.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	50.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,507.4	190,499.0
120	Нийтлэг татварын бус орлого	120,507.4	190,499.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,208,493.4	1,766,191.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,208,668.1	1,807,734.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,208,668.1	1,807,734.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,599,167.8	1,731,675.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,069,478.6	1,085,700.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,882.1	139,726.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,239.9	127,787.4
2104	Хангамж, бараа материалын зардал	70,376.0	64,929.3
2105	Нормативт зардал	48,208.0	97,350.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,683.4	48,746.5
2107	Томилолт, зочны зардал	9,138.0	6,329.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,497.3	22,361.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,664.6	138,745.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	609,500.3	76,058.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	146,135.5	216,644.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	107,653.0	83,307.9

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,653.0	83,307.9
2200	Дотоод эх үүсвэрээр	107,653.0	83,307.9
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-107,653.0	-83,307.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-64,042.6	-40,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	64,042.6	40,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-25,560.1	93,336.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	121,246.2	95,686.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,686.1	189,022.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,824,910.6	1,724,183.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,684,533.3	1,616,819.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,652,029.3	1,584,348.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,097,645.8	1,080,593.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,110.4	138,996.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,573.1	127,228.9
2104	Хангамж, бараа материалын зардал	49,385.5	49,381.0
2105	Нормативт зардал	44,593.6	44,510.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,776.2	31,055.5
2107	Томилолт, зочны зардал	6,257.0	6,229.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,198.8	8,764.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,488.9	97,589.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,504.0	32,471.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,504.0	32,471.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	96,877.3	67,363.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	43,500.0	40,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,824,910.6	1,806,267.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,059,318.8	1,057,857.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	598,859.4	596,704.7
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,860.5	5,369.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	149,871.9	146,335.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	77,218.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	151,102.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		221,067.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		221,067.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		178,940.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,106.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		729.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		558.5
2104	Хангамж, бараа материалын зардал		17,082.0
2105	Нормативт зардал		52,840.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		28,882.7

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2107	Томилолт, зочны зардал		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,596.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		60,044.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		42,126.9
2132	Бусад урсгал шилжүүлэг		30,220.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,906.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		221,139.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		221,139.1
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		71.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		71.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/41 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сум нь эрхэм зорилгоо “Сумын Засаг даргыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын мэдээллээр хангаж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, үйл ажиллагааны үр нөлөөтэй, үр ашигтай тасралтгүй жигд хэвийн нөхцөлийг хангах замаар улс төрийн аливаа нөлөөлөлд авталгүй, иргэддээ үнэнч шударга үйлчилж, иргэн рүүгээ чиглэсэн ажил үйлчилгээг явуулж, иргэдийн ажилгүйдлийг бууруулах, тухайн жилд зохион байгуулсан ажлаа иргэдэд түгээх, хүргэх мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулахад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төсөвт байгууллагуудын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, төсөв захирагч нарт дотоод аудитын тайланг хүргүүлсэн байна. Мөн аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс төсөвт байгууллагууд болон сумын үйл ажиллагаанд жил бүр хяналт, шалгалт, үнэлгээг хийж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,270,860.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 22,708.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 15,896.0 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,500.2 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	95,686.1	189,022.6	93,336.5
Авлага	232,726.2	386,290.4	153,564.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	297,018.9	361,620.0	64,601.1
Үндсэн хөрөнгө	4,135,336.9	4,092,335.3	(43,001.6)
Нийт хөрөнгө	4,760,768.1	5,029,268.3	268,500.2
Өр төлбөр	18,733.3	6,962.8	(11,770.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,742,034.8	5,022,305.5	280,270.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,760,768.1	5,029,268.3	268,500.2

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 189,022.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 93,336.5 мянган төгрөгөөр, авлагын дансны үлдэгдэл 386,290.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 153,564.1 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 361,620.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 64,601.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны өсөлт нь сум хөгжүүлэх сангаас сүүлийн хагас жилд зээл олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт жилийн эцэст олгогдсонтой холбоотой төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүйтэй холбоотой харилцахын дансны үлдэгдэл өссөн байна.

Авлагын дансны өсөлтөд Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөрийн үйлчилгээний авлага 200,940.8 мянган төгрөгийн авлага өсөлт нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны орлого 2,570,400.9 мянган төгрөг буюу өмнөх оноос 109,839.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 2,270,860.8 мянган төгрөг буюу өмнөх оноос 138,756.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь орон нутгийн төсвийг бууруулан баталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,022,305.5 мянган төгрөг болж өмнөх оноос 280,270.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс тус тус шалтгаалжээ.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Дэлгэрцогт сумын ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн “сумын 2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 1 дугаар тогтоолоор тайлант онд 84,825.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 111,851.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 131.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
Татварын орлого				
Үйл ажиллагааны орлого	10,000.0	13,449.8	3,449.8	134.5
Хадгаламжийн хīгийн орлого	10,600.0	13,757.7	3,157.7	129.8
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого		4,469.2	4,469.2	
Бууны албан татвар	1,000.0	1,020.0	20.0	102.0
Улсын тэмдэгтийн хураамж	2,500.0	2,844.3	344.3	113.8
Хог хаягдлын үйлчилгээ	2,500.0	3,870.9	1,370.9	154.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	600.0	600.0	-	100.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр		50.0	50.0	
Газрын төлбөр	1,600.0	1,910.9	310.9	119.4

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан				
Малын тоо толгойн албан татвар	41,925.9	40,640.2	(1,285.7)	96.9
Дүн	70,725.9	82,613.0	11,887.1	116.8
Татварын бус				
Хүү торгууль	14,000.0	29,122.2	15,122.2	208.0
Бусад орлого	100.0	116.8	16.8	116.8
Дүн	14,100.0	29,239.0	15,139.0	207.4
Нийт дүн	84,825.9	111,851.9	27,026.0	131.9

Эх сурвалж: Дэлгэрцогт сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 4,469.2 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 15,122.2 мянган төгрөгөөр давсан нь материаллаг дүнтэй байна.

Тус сумын нутаг дэвсгэрээр Өмнөговь, Дундговь, Улаанбаатар хотыг холбосон улсын чанартай автозам дайран өнгөрдөг тул тээврийн хэрэгслийн зөрчлийн торгуулийн орлого хүү, торгуулийн орлогыг материаллаг хэмжээгээр давахад нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дэлгэрцогт сумын ИТХ-ын 2020 оны 7 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,832,223.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,832,223.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Дэлгэрцогт сумын ИТХ-ын 2021 оны 01 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт тодотгол хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 7,313.2 мянган төгрөгөөр бууруулан, 1,824,910.6 мянган төгрөгөөр баталсан байна. Тусгай зориулалтын шилжүүлгийг нэмэгдүүлэн орон нутгийн төсвийг хасаж, урсгал зардлыг нэмэгдүүлэн эргэж төлөгдөх зээлийн зардлыг хасаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,824,910.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,684,533.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 96,877.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 43,500.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,059,318.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 598,859.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 16,860.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 149,871.9 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,057,857.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 596,704.7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5,369.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 146,335.3 мянган төгрөг, нийт 1,806,267.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 87,940.7 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 77,940.7 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 58,394.6 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4,894.6 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт бөгөөд тодотголоор орлогын төлөвлөгөөг бууруулан баталсан, тайлант онд өмнөх оны төлбөрийн акт төлөгдсөн зэргээс шалтгаалан төлөвлөгөө давж биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,724,183.3 мянган төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь урсгал зардал 67,713.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 29,513.7 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлийн гүйлгээ хийгдээгүйгээс 3,500.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,460.9 мянган төгрөгийг улсын төсөвт, 8,248.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 32,116,7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 163,459.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25,562.8 мянган төгрөг, нийт 221,139.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 5,836.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 558.5 мянга, хангамж бараа материалын зардалд 17,082.0 мянга, нормативт зардал 52,840.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 28,882.7 мянга, томилолт зочны зардалд 100.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 13,596.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 60,044.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 30,220.0 мянган төгрөг, нийт 209,160.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 11,906.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 71.4 мянган төгрөгийг харилцахын үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ

Тайлант онд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

Засаг даргын Тамгын газар:

1. Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м³ тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь 23,629.5 мянган төгрөгийн нэхэмжлэхийг ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул хуучин гэрээний үнэ 22,036.1 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

2. Байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн малчдад туслах хандивын аяныг өрнүүлэн 23,223.6 мянган төгрөгийг төвлөрүүлснээс 10,015.0 мянган төгрөгийг малчдын дансанд шилжүүлж, үлдсэн 13,208.6 мянган төгрөгийг шатахууны талон болгон тараасан байна;

Цэцэрлэг:

Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м³ тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь 19,572.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул гэрээний үнэ 18,581.6 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Эрүүл мэндийн төв:

1. Ковид-19 цар тахал тархсантай холбоотой эмийн зардал өмнөх оноос 6.8 дахин өссөн байна. Тайлант онд эм боох материалын дансанд хандив, тусламжаар 100,127.8 мянган төгрөг, төсвийн

хөрөнгөөр худалдан авсан 64,260.5 мянган төгрөг, нийт 164,388.3 мянган төгрөгөөр эм боох материалыг орлого авч, 153,011.9 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

2. Ковид-19 халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн Эрүүл мэндийн газраар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 90 ширхэг эмийн үнийн зөрүү 1,156.6 мянган төгрөгийн зөрүү, анхан шатны баримтыг ирүүлээгүй тул орлого аваагүй байсан 9,871.0 мянган төгрөгийн эмийг Эрүүл мэндийн газартай тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусган залруулга хийсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудаас сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн аудитаар төсөл хэрэгжүүлэгч иргэн нь гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд 7,388.1 мянган төгрөгийн хохирол учруулсан зөрчилд төлбөрийн актыг тогтоосон.

Сумын Засаг дарга нь тус иргэнээр хохирлыг барагдуулахаар Дундговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэх гаргасан байна. Уг нэхэмжлэхийн дагуу Дундговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 139/ШШ/2022/00092 дугаар шүүгчийн захирамжаар 2 тал эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргажээ. Эвлэрлийн гэрээгээр хариуцагч тал үндсэн зээл, зээлийн хүүг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор төлж барагдуулахаар тохирч эвлэрсэн байна.

Иймд дээрх төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжих шатандаа яваа гэж үзэн материаллаг зөрчлийн дүнгээс хассан.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сум нь 2021 онд нийт 251,233.8 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулан мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Эрчим

хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлүүдийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Дэлгэрцогт сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 12,324.3 мянган төгрөгийн 11 төлбөрийн акт, 14,544.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага хүргүүлсэн ба бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	11	12,324.3	11	12,324.3			100.0
Албан шаардлага	14	14,544.6	14	14,544.6			100.0
Зөвлөмж							100.0
Нийт	25	26,868.9	25	26,868.9			100.0

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 344,406.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 312,798.8 мянган төгрөгийн 10 алдааг аудитын явцад залруулж, 7,388.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24,219.1 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 9.2 хувийг залруулагдаагүй, 90.8 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумын нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тусгай зориулалтын сангуудын тайланд хийсэн аудитаар нийт 2,728.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 800.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 1,928.6 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 70.7 хувийг залруулагдаагүй, 29.3 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Нийт алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 313,598.8 мянга, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 7,450.6 мянга, арвилан хэмнэлттэй холбоотой 4,570.6 мянга, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 21,514.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд данс андуурсан 800.0 мянган төгрөгийн гүйлгээг зардлаар тайлагнасан;

4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 1,928.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/											
д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЕБС	1	-					1	-		
2	ЗДТГ	2	5,208.0					2	5,208.0		
3	ЭМТ	1	-					1	-		
Дүн		4	5,208	0	0	0	0	4	5,208	0	0
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЕБС	1	465.1	1	465.1						
2	ЭМТ	3	280,400.9	2	275,830.0			1	4,570.9		
3	ЗДТГ	7	49,981.4	5	35,603.7			2	14,377.7		
4	ИТХ	2	962.5	1	900.0			1	62.5		
6	СХС	1	7,388.1			1	7,388.1				
7	ТЗС	2	2,728.6	1	800.0			1	1,928.6		
8	ТТЗ	0	-								
Дүн		16	341,926.6	10	31,3598.8	1	7,388.1	5	20,939.7	0	0
Нийт зөрчлийн дүн		20	347,134.6	10	313,598.8	1	7,388.1	9	26,147.7	0	-